

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД  
ОРУУЛАХ КОМИССЫН ДҮГНЭЛТ

2025 оны 03 сарын 14-ны өдөр

Дугаар

БА-077/2025

Улаанбаатар хот

Нэг. Удиртгал хэсэг

Монгол Улсын нийслэлийн Баянгол дүүргийн 9 дүгээр хороонд баригдсан өндөр төвөгшилтэй ангиллын 2 давхар зорьтой, 12 давхар, 1 блок, 2 (хоёр) автомашины дулаан зогсоолтой, 16 (арван зургаа) агуулахтай, үйлчилгээтэй 81 (наян нэг) айлын орон сууцны зориулалттай барилга, Ф200мм-ийн голчтой хуванцар хоолой 425м урттай цэвэр усны шугам, 1-р хэлхээний гадна шугам Ф273мм-н голчтой 375м урттай дулааны хос шугам бүхий ус дулаан дамжуулах төвийн барилга байгууламжид Засгийн газрын 2021 оны 07 сарын 20-ны өдрийн 212 дугаар тогтоол, нийслэлийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/503 дугаар захирамжийн шийдвэрээр байгуулагдсан 16 хүний бүрэлдэхүүнтэй барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2025 оны 02 сарын 12-ны өдрөөс эхлэн 1 хоногийн хугацаанд ажиллан тухайн барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийв.

Хоёр. Ерөнхий мэдээлэл

- 2.1. Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээний 2023/06/08 огноо, 0012911 дугаар, БАЗГ2023/316
- 2.2. Барилга байгууламжийн зураг төслийн шифр дугаар ЕГ Шифр: ГӨ-13/22
- 2.3. Захиалагч: Иргэн М.Насанбат, ХМ7106101 регистрийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 3-р хороо, 5-р хороолол 14а байр 51 тоот, 94033342 холбоо барих утас, [nasanbat3342@gmail.com](mailto:nasanbat3342@gmail.com) цахим хаяг;
- 2.4. Барилгын ажлын гүйцэтгэгч: “Твинхаус констракшн” ХХК оноосон нэр, 9011270102 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5449421 регистрийн дугаар, БУ16-678/21 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 9-р хороо, 3-р хороолол Дулаахан байр хотхоны 42-р байр 1-р давхар 1-1 тоот, 7014-2856 холбоо барих утас, [info@twinhouse.mn](mailto:info@twinhouse.mn) цахим хаяг;
- Барилгын ажлын гүйцэтгэгч: “Их Жаргант” ХХК оноосон нэр, 9011149133 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 2773031 регистрийн дугаар, БУ16-905/21 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 9-р хороо, 3-р хороолол Дулаахан байр хотхоны 42-р байр 1-р давхар 1-1 тоот, 9111-9799 холбоо барих утас, [info@ikhjargant.mn](mailto:info@ikhjargant.mn) цахим хаяг;
- 2.5. Барилгын ажлын Туслан гүйцэтгэгч байгууллага: “Гурван гэгээн гал” ХХК оноосон нэр, 1011005116 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 3559971

ХЯНАЛТ ЦАЛГАЛТЫН  
ТАСГАЙ  
Барилга байгууламжийг ашиглалтад  
оруулах комисс

регистрийн дугаар, БУЗ-378/23 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Өвөрхангай аймаг, Гучин-Ус 1-р баг Хөөвөр, 9911-1201 холбоо барих утас, [gurvangegeengal@gmail.com](mailto:gurvangegeengal@gmail.com) цахим хаяг;

Барилгын ажлын Туслан гүйцэтгэгч байгууллага: “Гэрэлт Урсгал” ХХК оноосон нэр, 9011129128 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5185211 регистрийн дугаар, ӨБ19-1130/18 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: ЧД-ийн 17-р хороо, Сурагчийн 9-74 тоот, 8811-9557 холбоо барих утас, [g\\_ursgal@yahoo.com](mailto:g_ursgal@yahoo.com) цахим хаяг;

Барилгын ажлын Туслан гүйцэтгэгч байгууллага: “Төгс эгшиглэнт цамхаг” ХХК оноосон нэр, 9011404108 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5700779 регистрийн дугаар, барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: БЗД 1-р хороо, 12 хороолол, 20/1 15 тоот, 9911-3523 холбоо барих утас, цахим хаяг;

Барилгын ажлын Туслан гүйцэтгэгч байгууллага: “Галт эрчим” ХХК оноосон нэр, 9011571035 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 6007937 регистрийн дугаар, БУ17-457/20 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: УС бохт, Сонгинохайрхан дүүрэг 8-р хороо, АБ центр 903 тоот, 8901-1020 холбоо барих утас,

- 2.6. Барилга байгууламжийн зураг төсөл зохиогч байгууллага: “Голомт Өргөө” ХХК оноосон нэр, 9011068029 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 2787555 регистрийн дугаар, ЗТ12-310/24 зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: БЗД 16-р хороо, 16-р хороолол, 9-45, 8808-4998 холбоо барих утас, [golomturguu@yahoo.com](mailto:golomturguu@yahoo.com) цахим хаяг

Барилга байгууламжийн зураг төсөл зохиогч байгууллага: “ТДХ” ХХК оноосон нэр, 901169013 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5997941 регистрийн дугаар, ЗТ18-276/24 зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Сонгинохайрхан дүүрэг 11-р хороо, АОС 3-1 тоот, 9910-0914 холбоо барих утас,

Барилга байгууламжийн зураг төсөл зохиогч байгууллага: “Арбэл Алтай” ХХК оноосон нэр, 9011106027 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5143594 регистрийн дугаар, ЗТ12-716/22 зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: БЗД 4-р хороо, 15-р хороолол, 11-20 тоот, 9611-4455 холбоо барих утас,

- 2.7. Барилга байгууламжийн ашиглагч, өмчлөгч байгууллага:

“Твинхаус констракшн” ХХК оноосон нэр, 9011270102 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5449421 регистрийн дугаар, БУ16-678/21 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 9-р хороо, 3-р хороолол Дулаахан байр хотхоны 42-р байр 1-р давхар 1-1 тоот, 7014-2856 холбоо барих утас, [info@twinhouse.mn](mailto:info@twinhouse.mn) цахим хаяг;

## 2.8. Барилга байгууламжийн төлөв байдал: **Шаардлага хангасан**

Гурав. Дүгнэлтийн хэсэг

✓ Барилга байгууламжийг ашиглалтад оруулах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангасан барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул

□ Барилга байгууламжийг ашиглалтад оруулахаас татгалзах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангаагүй, барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдээгүй, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаагүй тул

- Заасан хугацаанд үүрэг даалгаврын биелэлт хангаагүй тул

ТТ ШАЛГАЛТ  
ААЗАР  
ууламжийг аш  
уулах комисс

3.1 Энэ өндөр төвөгшилтэй ангиллын 2 давхар зорьтой, 12 давхар, 1 блок, 2 (хоёр) автомашины дулаан зогсоолтой, 16 (арван зургаа) агуулахтай, үйлчилгээтэй 81 (наян нэг) айлын орон сууцны зориулалттай барилга, Ф200мм-ийн голчтой хуванцар хоолой 425м урттай цэвэр усны шугам, 1-р хэлхээний гадна шугам Ф273мм-н голчтой 375м урттай дулааны хос шугам бүхий ус дулаан дамжуулах төвийн зориулалттай барилга байгууламж түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийж, барилгын ажлын гүйцэтгэл, чанарт үнэлгээ, дүгнэлт өгсний үндсэн дээр комиссоос ДҮГНЭСЭН нь:

Энэ барилга байгууламжийн барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан гэж үзээд ашиглалтад оруулах нь зүйтэй гэж дүгнэв.

3.2 Барилга байгууламжийг ашиглалтад оруулах болсонтой холбогдуулан захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч байгууллагуудад даалгах нь:

а) барилга байгууламжийн иж бүрэн баримт бичгийн эх хувийг архивт, үлдэх хувийг ашиглагч буюу өмчлөгч, эзэмшигч байгууллагад ... хоногийн дотор багтаан шилжүүлэх;

б) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаанд ашиглалтын хэвийн нөхцөлийг хангах болон уг хугацаа дуусгавар болохтой холбоотой хууль тогтоомжид заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

3.3 Ашиглагч байгууллагад:

а) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацааг дуусгавар болгоход оролцох;

б) барилга байгууламжийн хувийн хэргийг хөтөлж эхлүүлэх;

в) барилга байгууламжийн хэвийн ашиглалттай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг үүгээр даалгаж байна.

3.4 Комиссын акт 4 хуудас, хуралдааны тэмдэглэл 6 хуудас, комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн жагсаалт 32 хуудас материал болон барилга байгууламжийн бичиг баримтын жагсаалт болох материалыг дүгнэлтэд хавсаргаж байна.

#### Дөрөв. Дүгнэлтийн баталгаажуулалт

4.1 Өндөр төвөгшилтэй ангиллын 2 давхар зорьтой, 12 давхар, 1 блок, 2 (хоёр) автомашины дулаан зогсоолтой, 16 (арван зургаа) агуулахтай, үйлчилгээтэй 81 (наян нэг) айлын орон сууцны зориулалттай барилга, Ф200мм-ийн голчтой хуванцар хоолой 425м урттай цэвэр усны шугам, 1-р хэлхээний гадна шугам Ф273мм-н голчтой 375м урттай дулааны хос шугам бүхий ус дулаан дамжуулах төвийн барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүгнэлт гаргасан:

Баянгол дүүргийн 9 дүгээр хороо, иргэн М.Насанбатын захиалгатай, ус дулаан дамжуулах төв, үйлчилгээтэй орон сууцны барилга

Комиссын дарга: Хяналт шалгалтын газрын Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Нарийн бичгийн дарга: Захиалагч иргэн



(А.Мөнгөн)

(М.Насанбат)

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үүрэг даалгаврын биелэлтийн хуудасны хамт хүчинтэй.



БАЯНГОЛ ДҮҮРГИЙН 9 ДҮГЭЭР ХОРОО, ИРГЭН М.НАСАНБАТЫН  
ЗАХИАЛГАТАЙ, 2 ДАВХАР ЗООРЬТОЙ, 12 ДАВХАР, 1 БЛОК, 2 АВТОМАШИНЫ  
ДУЛААН ЗОГСООЛТОЙ, 16 АГУУЛАХТАЙ, ҮЙЛЧИЛГЭЭТЭЙ 81 АЙЛЫН ОРОН  
СУУЦНЫ ЗОРИУЛАЛТТАЙ БАРИЛГА, Ф200ММ-ИЙН ГОЛЧТОЙ ХУВАНЦАР  
ХООЛОЙ 425М УРТТАЙ ЦЭВЭР УСНЫ ШУГАМ, 1-Р ХЭЛХЭЭНИЙ ГАДНА  
ШУГАМ Ф273ММ-Н ГОЛЧТОЙ 375М УРТТАЙ ДУЛААНЫ ХОС ШУГАМ БҮХИЙ УС  
ДУЛААН ДАМЖУУЛАХ ТӨВИЙН БАРИЛГЫГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ  
КОМИССЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2025 оны 02 дугаар сарын 12

Улаанбаатар хот

Баянгол дүүргийн 9 дүгээр хороо, иргэн М.Насанбатын захиалгатай, 2 давхар зорьтой, 12 давхар, 1 блок, 2 автомашины дулаан зогсоолтой, 16 агуулахтай, үйлчилгээтэй 81 айлын орон сууцны зориулалттай барилга, Ф200мм-ийн голчтой хуванцар хоолой 425м урттай цэвэр усны шугам, 1-р хэлхээний гадна шугам Ф273мм-н голчтой 375м урттай дулааны хос шугам бүхий ус дулаан дамжуулах төвийн барилгыг ашиглалтад оруулах комиссын хуралдаан тус барилгыг ашиглалтанд оруулах комисс 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдөр 11 цагт 17 гишүүний бүрэлдэхүүнтэй эхэлж, 14 цагт дуусав.

Хуралд:

- |  |                |
|--|----------------|
| 1. Комиссын дарга: Хяналт шалгалтын газрын Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч | А.Мөнгөн       |
| 2. Комиссын нарийн бичгийн дарга: Захиалагч  | М.Насанбат     |
| 3. Хяналт шалгалтын газар, Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтэс, Барилга техникийн хяналтын улсын /ахлах/ байцаагч         | Ц.Алтансүх     |
| 4. Хяналт шалгалтын газар, Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтэс, Барилга техникийн хяналтын улсын /ахлах/ байцаагч         | Б.Тэмүүлэн     |
| 5. Хяналт шалгалтын газар, Дэд бүтцийн стандартын хяналтын хэлтэс, Эрчим хүчний хяналтын улсын ахлах байцаагч                            | Э.Цогзолмаа    |
| 6. Улаанбаатар Дулааны сүлжээ ТӨХК Шинэ хэрэглэгчийн холболтын албаны дарга  | Д.Сүхбат       |
| 7. Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК, Техник хяналтын ахлах инженер   | Б.Дашдорж      |
| 8. Мэдээлэл Холбоо Сүлжээ ТӨХК Технологийн удирдлага төлөвлөлтийн газар Дэд бүтэц төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн                      | Э.Уранчимэг    |
| 9. Ус сувгийн удирдах газар, Хэрэглэгчид үйлчлэх төвийн менежер  | Б.Жамбалцанжид |
| 10. Онцгой байдлын ерөнхий газар Барилгын зураг төсөл техникийн гүйцэтгэл хариуцсан ахлах мэргэжилтэн Дэд хурандаа                       | М.Батсайхан    |
| 11. Үндэсний Төв Архив, Зураг төслийн баримтын архивч  | Н.Өлзийжаргал  |
| 12. Барилгын хөгжлийн төв, Норм, нормативын хэлтэс,  |                |

Барилга байгууламжийг байнгын ашиглалтанд хүлээн авах, Норм нормативын сангийн бүрдүүлэлт хариуцсан мэргэжилтэн	О.Ундрах
13. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах байгууллага, төлөөлөл	Б.Болормаа
14. Ашиглалт хариуцах байгууллага ОСНААУГ	Б.Баасансүрэн
15. Зураг төсөл зохиогч байгууллага Голомт Өргөө ХХК	Ц.Баянмөнх
16. Барилгын ажил гүйцэтгэгч Твинхаус констракшн ХХК	Д.Эрдэнэбаатар
17. Барилгын ажил гүйцэтгэгч "Их Жаргант" ХХК	М.Өсөхбаяр

#### ИРЦИЙН БАЙДАЛ:

- Мэдэгдэл хүлээн авсан - 17
- Хүрэлцэн ирсэн - 17
- Хуралд оролцож үүрэг даалгаврын биелэлтээр санал гаргасан – 17

#### ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Баянгол дүүргийн 9 дүгээр хороо, иргэн М.Насанбатын захиалгатай, 2 давхар зорьтой, 12 давхар, 1 блок, 2 автомашины дулаан зогсоолтой, 16 агуулахтай, үйлчилгээтэй 81 айлын орон сууцны зориулалттай барилга, Ф200мм-ийн голчтой хуванцар хоолой 425м урттай цэвэр усны шугам, 1-р хэлхээний гадна шугам Ф273мм-н голчтой 375м урттай дулааны хос шугам бүхий ус дулаан дамжуулах төвийн барилгын ажлын гүйцэтгэл ашиглалтад оруулах шаардлага хангасан эсэх талаар хэлэлцэв.

#### СОНССОН НЬ:

Комисст ажилласан гишүүд барилга байгууламжийн зураг төсөв, баримт бичиг, барилгын ажлын гүйцэтгэлийг хянаж танилцаад дараах саналуудыг гаргав.

Нийслэлийн хяналт шалгалтын газар, Барилгын стандарт, барилгын аюулгүй байдлын хяналтын хэлтсийн Барилгын техникийн хяналтын улсын байцаагч Ц.Алтансүх

- Барилгын дотор заслын үйлчилгээний ажил бүхэлдээ гүйцэтгэл дутууг ажлын 14 хоногт багтаан гүйцэтгэх.
- Цахилгаан сантехник, холбоо дохиололтой холбоотой тоноглол гүйцээж түүнтэй уялдан гарах заслал чимэглэлийн ажлыг гүйцээх
- Шатны хонгилд заслал гүйцээх
- Барилгын цан мөстөлт их байгаа тул барилгын чийг бүрэн гарсны дараа заслал чимэглэл гүйцээх талаар тайлбар албан бичиг баталгааг Захиалагч Гүйцэтгэгч нар гаргах
- В2, В1 давхрын заслал чимэглэлийн ажлыг бүрэн дуусгах
- Барилгын хаяавч тохижилтын ажлыг гүйцэтгэх
- Хүүхдийн тоглоомын талбайг гүйцэтгэх тайлбар ирүүлэх
- Барилга архитектур корпорациас суурийг М350 байхаас 27.8мПа гарсан байна. Барилгын зураг төслөөр В25 гэж заажээ. Энэ асуудал дээр зохиогч, гүйцэтгэгч тайлбар ирүүлэх
- Дээврийн усны хаяалга зураг төслийн дагуу гүйцэтгэх
- Тагтны хэсэгт тэгшилгээг зураг төслийн дагуу гүйцэтгэх
- Зохиогч айлын хаалган дээр тайлбар гаргах

- Өөрчлөлтийн зураг төсөл шалгуулах
- Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд оруулах саналтай байна.

Нийслэлийн хяналт шалгалтын газар, Барилгын стандарт, барилгын аюулгүй байдлын хяналтын хэлтсийн Барилгын техникийн хяналтын улсын байцаагч **Б.Тэмүүлэн**

- Бохир усны худагт, худгуудийг хүзүүвч кольцо, тоосгон байгааг зориулалтын кольцо болгон солих
- Бохир усны худагт ажлын талбай гаргах
- Галын гидрант зураг төсөлд заасан худагт угсрах
- Цэвэр усны гүйцэтгэлийн зураг төсөл хийлгэж баталгаажуулах
- Техникийн нөхцөлийг 2 гарсан байгааг УСУГ-аас нэгтгүүлж хариуг авах
- УДДТ-ийн дутуу ажлуудыг гүйцээх
- Нөөцийн сав гарал, үүслийн гэрчилгээ эрүүл ахуйн шинжилгээний бичиг баримт шалгуулах
- Бохир усны гүйцэтгэлийн зураг төслийг баталгаажуулах, батлуулах
- Дотор сантехникийн ажлуудыг гүйцээж хийх
- Цэвэр бохир усны худгууд дарагдсан байгааг үзлэг хийх боломжтой болгох
- В1 давхарт ус зайлуулах праямокнд насос суулгаж өгөх

Нийслэлийн хяналт шалгалтын газар, Дэд бүтцийн стандарт, хяналтын хэлтэс, Эрчим хүчний хяналтын улсын байцаагч байдлын хяналтын хэлтсийн Барилгын техникийн хяналтын улсын байцаагч **Э.Цогзолмаа**

- УДДТ-ийн тоног төхөөрөмж, шугам сүлжээ угсралтыг бүрэн дуусгаж баталгаа албан тоот ирүүлэх, хаягжуулах
- Холигч узелийн шугам сүлжээг цэвэрлэж хаягжуулах, фото зургаар баталгаажуулж шалгуулах
- В2, В1 давхрын агаар сэлгэлтийн ажлыг бүрэн угсарч дуусгах баталгаа албан тоот ирүүлэх
- Давхар бүрийн коллекторыг цэвэрлэж, хаягжуулах
- Агаар сэлгэлтийн угсралтын ил далд актыг баталгаажуулах
- Айл өрх бүрийн халаах хэрэгслүүд дээр термостать винтель суурилуулах
- УДДТ болон холигч насосны узелийг угсарсан ил далд актыг баталгаажуулах

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд оруулах саналтай

Барилгын хөгжлийн төв ТӨҮГ-ийн инженер **О.Ундрах**

- Техникийн давхрын дээврийн усны буултыг дээврээс дээш 30см хүртэл буулгах.
- Б сууцны лифтний хананд зураг төслийн дагуу дуу тусгаарлагч хийсэн акт, фото зураг нөхөж үзүүлэх
- Заслын дутуу ажлуудыг бүрэн дуусгах
- Барилгын тухай хуулийн 5.7.1-д заасны дагуу төлбөрийг тооцуулж төлөх
- Цонх 3 давхар шилтэй байхаас 2 давхар хийсэн байна. Зохиогч тайлбар албан бичиг ирүүлэх

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд оруулах саналтай байна.  
Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХК-ийн мэргэжилтэн **Э.Уранчимэг**

- Шинээр хийсэн худаг сувагчлалыг МХС-д техникийн актаар хүлээлгэж өгөх
- Гадна холбооны шинээр сунгагдсан техникийн нөхцөлийг акт бичиг баримтад хавсаргах
- Дотор холбооны актуудын гарын үсгийн баталгаажилт дутуу гүйцээж зуруулах
- Барилгын гадна камер В1 давхрын камеруудыг зургийн дагуу суурилуулах, бүрэн ажиллагаанд оруулах
- Техникийн өрөө байхгүй, техникийн өрөөгөө тогог төхөөрөмжийг бүрэн суурилуулах, бэлэн болгож дэлгэц hard NVR суурилуулж камеруудаа бүрэн ажиллагаанд оруулах
- ГХ-ны шинээр батлагдсан ажлын зургийн гарун үсгийн баталгаажилт дутуу гарын үсгийг баталгаажуулж гүйцээж зуруулах

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд оруулах саналтай байна.

УС сувгийн удирдах газар, Хэрэглэгчдэд үйлчлэх төвийн менежер **Б.Жамбалцанжид**

- №461/24 тоот техникийн нөхцөлийн дагуу цэвэр усны холболт хийгдээгүй тул холбох цэгийг өөрчилсөн албан бичиг авах, ирүүлэх
- Бохир усны холболтын худгийг ил гаргах
- Бохир усны шугамын ажлын зургийг батлуулах (өөрчлөлтийн)
- Бохир усны шугамын ил далд ажлын актыг засаж баталгаажуулах
- Усны нөөцийн санг халдваргүйжүүлэлт хийлгэж усны шинжилгээ хийлгэх
- Гаргалгаа бохир усны худгийн тоосгон өрлөгтэйг бетон хүзүүвчээр солих, ажлын талбайг янзлах

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд оруулах саналтай байна.

Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК-ийн Шинэ хэрэглэгчдийн холболтын хэлтсийн дарга **Д.Сүхбат**

- Халаах хэрэгсэлд термостат винтель суурилуулах
- Дулааны узельд норм дүрэмд нийцүүлэн угсралт хийх
- Давхрын самбар хаяг, бичлэг виркжүүлэлт хийх
- Үйлчилгээний хэсгийн дутуу ажлыг гүйцээж фото зургаар
- 0.4Кв-ын кабелин трасс мэдээллийн санд оруулах

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд оруулах саналтай байна.

ОБЕГазар, Гал түймэртэй тэмцэх газар, Гал түймрийн улсын хяналтын хэлтсийн барилгын зураг төсөл хяналтын тасаг Дэд хурандаа **М.Батсайхан**

- Цахилгаан шатны өмнөх хаалга хийх
- Зоорийн давхарт гүйцэтгэлийн зураг хянуулах
- ГК даралттай усаар хангах
- Дотор заслын материалд зохиогч тайлбар алба бичиг өгөх, дүгнэлт үзүүлэх
- Айлуудын тагтанд шатах материал дэвсэхгүй
- Усны нөөцийн савтай өрөөг өрлөг хийж хаах
- Галын дохиоллын систем хэвийн болгох, дутуу хийгдсэн гүйцээх, хүлээн авагч станцыг хүн 24 цагаар байрлах өрөөг тасалгаанд байрлуулах

Г ШАЛ  
ГАЗАР

уламжи  
улах ко

- Хаалга бие биенээсээ хамааралтай онгойж байгаад зохиогч тайлбар ирүүлэх
- Барилгын гадна хананы дулаалга материалын гал тэсвэршилтийн зэрэг тогтоолгосон дүгнэлт үзүүлэх
- Галын аюулгүй байдлын тухай хуулийн 18.3-р зүйлийг хангасан эсэх талаар зураглал хийж баталгаа өгөх
- Цахилгааны ерөнхий шитний өрөөнд бие даасан гал унтраах автомат төхөөрөмж суурилуулах
- Баруун талд үргэлжлүүлэн барьсан нэгдсэн зоорийн давхрын барилгын зураг төсөл шалгуулах

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд оруулах саналтай байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах байгууллага **Б.Болормаа**

- Үйлчилгээний төврүү орох хаалганы пандусыг стандартын дагуу хийх
- Орцруу орох хаалганы пандусыг стандартын дагуу хийх
- Замаасаа орцруу орох хэсгийн замыг цэвэрлэж янзлах, мөн тэгш болгон янзлах, шаардлагатай
- Цахилгаан шатанд харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан давхар зарлагч суурилуулах
- Гаднах авто машины зогсоолд ХБИ зориулсан босоо болон хэвтээ тэмдэглэгээ хийх
- Үйлчилгээний төвийн ариун цэврийн өрөөнүүдэд ХБИ зориулсан тоноглол хийх

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд оруулах саналтай байна.

Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК, Техник хяналтын инженер **Б.Дашдорж**

- 0.4Кв-ын ерөнхий щитний өрөөнд хаалганы босго өндөрлөж цутгаж хийх, хаяг бичиж виржүүлэлт хийх, щитний хаалганд схем байрлуулах
- Давхрын самбар хаяг, бичлэг виржүүлэлт хийх
- Үйлчилгээний хэсгийн дутуу ажлыг гүйцээж фото зургаар шалгуулах
- 0.4Кв-ын кабелин трасс мэдээллийн санд оруулах

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд авах саналтай байна.

Үндэсний төв архивын газар, Зураг төслийн баримтын ахлах архивч **Н.Өлзийжаргал**

- Ил далд ажлын актыг бүрэн баталгаажуулах
- Барилга угсралтын ажлыг гүйцэтгэсэн тэмдэглэлийг баталгаажуулах
- Баримт бичгийн бүрдлийг нийтлэг жагсаалтын дагуу бүрэн бүрдэлтэй бүрдүүлэх
- Хуудас дугаарлаж дотоод товъёог үйлдэх
- Ажлын зураг болон холбогдох баримтын эх хувийг архивд хүлээлгэж өгөх
- Хуулбар хувийг ашиглагч байгууллагад хүлээлгэн өгөх

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд авах саналтай байна.

ОСНААУГ - **Б.Баасансүрэн**

- Айлуудын өрөөний салбар шугам бэхэлгээ хийгдээгүй хийх

- Халаалтын удирдлагын самбар, кабель утас цэгцлэх

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд авах саналтай байна.

Комиссын дарга: Нийслэлийн хяналт шалгалтын газрын, Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

**А.Мөнгөн**

- БНБД 11-04-06 Зохиогчийн дүгнэлт шинэчлэх
- БХТ-ийн 14.3, 14.6-ийн дагуу чанарын баталгаа гаргах
- Зохиогч давхар бүрт 4 айлын хаалга мөргөлдөж байгаад тайлбар ирүүлэх
- Гадна тохижилтын ажлыг гүйцээх (хугацаатай албан тайлбар бичиг өгөх)
- Хүүхдийн тоглоомын талбайг хийж гүйцээх VCS1405B ерөнхий шаардлагын дагуу хийх хугацаатай албан бичиг ирүүлэх
- Айлуудын дотор засал гүйцээх
- 212 тогтоолын 8.1-ийг биелүүлэх
- Комиссийн гишүүдийн үүрэг даалгаврыг биелүүлэх


Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд оруулах саналтай байна.

**ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:**

Баянгол дүүргийн 9 дүгээр хороо, иргэн М.Насанбатын захиалгатай, 2 давхар зорьтой, 12 давхар, 1 блок, 2 автомашины дулаан зогсоолтой, 16 агуулахтай, үйлчилгээтэй 81 айлын орон сууцны зориулалттай барилга, Ф200мм-ийн голчтой хуванцар хоолой 425м урттай цэвэр усны шугам, 1-р хэлхээний гадна шугам Ф273мм-н голчтой 375м урттай дулааны хос шугам бүхий ус дулаан дамжуулах төвийн барилгыг байнгын ашиглалтад оруулах комиссын гишүүдийн гаргасан үүрэг даалгаврын биелэлтийг хангуулах, биелэлтээр комиссын дүгнэлтийг баталгаажуулж, ашиглалтад оруулахаар шийдвэрлэв.

ТГАНД

Танилцсан:  
Хяналт шалгалтын газрын  
Барилга байгууламжийн ашиглалт,  
бүртгэлийн хэлтсийн даргын албан  
үүргийг түр орлон гүйцэтгэгч



(А.Мөнгөн)

Тэмдэглэл хөтөлсөн:  
Захиалагч иргэн

(М.Насанбат)